



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022-02-24 № 252  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН  
ТӨВ НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ  
Д.ИНДРА ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ





## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2022/788/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга, аудитын менежер <b>З.Мөнхбаяр</b></p> <p>Утас: 327734 Цахим хаяг: <a href="mailto:munkhbayarz@audit.gov.mn">munkhbayarz@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Ш.Наран Утас: 261628 Цахим хаяг: <a href="mailto:Naransh@audit.gov.mn">Naransh@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Ш.Одням Утас: 260512 Цахим хаяг: <a href="mailto:Odnyamsh@audit.gov.mn">Odnyamsh@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20



## Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022-02-04 № 252  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

УЛААНБААТАР ХОТЫН НИЙТИЙН  
ТӨВ НОМЫН САНГИЙН ЗАХИРАЛ  
Д.ИНДРА ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

002020203



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>134,623,818.86</u></b>	<b><u>130,653,701.52</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	26,023,338.00	7,384,174.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	26,023,338.00	7,384,174.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	26,023,338.00	7,384,174.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	26,023,338.00	7,384,174.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,729,805.91	19,593,000.37
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	362,505.91	19,392,288.37
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	5,367,300.00	200,712.00
3351	Байгууллагаас авах авлага	1,800,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,567,300.00	200,712.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	102,870,674.95	103,676,527.15
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	102,870,674.95	103,676,527.15
35410	Бичиг хэргийн материал	52,036,680.00	48,851,100.00
35420	Аж ахуйн материал	3,602,955.80	3,065,838.00
35470	Бусад хангамжийн материал	47,231,039.15	51,759,589.15
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,075,454,818.92</u></b>	<b><u>8,056,488,046.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	8,075,454,818.92	8,056,488,046.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,926,516,939.04	7,908,759,333.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,873,145,543.24	7,035,811,054.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-229,104,851.52	-343,657,277.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,123,666.84	-29,690,666.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	533,040,218.32	552,793,318.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	-245,804,408.13	-322,922,370.22
39208	Хуримтлагдсан элэгдэл	-188,011,822.60	-207,810,111.00
39217	Ном	827,304,889.12	844,164,349.12
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	148,937,879.88	147,728,713.20
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,897,500.12	-6,106,666.80
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,210,078,637.78</u></b>	<b><u>8,187,141,748.47</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>51,839,109.45</u></b>	<b><u>7,384,174.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	51,839,109.45	7,384,174.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	51,839,109.45	7,384,174.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	25,569,187.45	00.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	26,023,338.00	7,384,174.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	246,584.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	246,584.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>8,158,239,528.33</u></b>	<b><u>8,179,757,574.47</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,158,239,528.33	8,179,757,574.47
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-329,039,463.04	-307,521,416.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	21,518,046.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>8,210,078,637.78</u></b>	<b><u>8,187,141,748.47</u></b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,701,313,401.00</b>	<b>1,695,046,001.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,295,219.00</b>	<b>188,303,501.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,295,219.00	188,303,501.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,295,219.00	188,303,501.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,295,219.00	25,637,690.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	162,665,511.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,676,018,182.00</b>	<b>1,506,742,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	93,250,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	50,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	43,250,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,379,694,900.00	1,413,492,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,379,694,900.00	1,413,492,500.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	296,323,282.00	00.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	296,323,282.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,621,873,107.36</b>	<b>1,673,527,954.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,621,873,107.36</b>	<b>1,673,527,954.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,478,426,292.10	1,620,250,047.44
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	912,716,673.74	965,156,633.98
210101	Үндсэн цалин	620,412,207.49	873,385,949.48
210102	Нэмэгдэл	160,267,080.11	91,770,684.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,297,838.05	00.00
210104	Урамшуулал	76,739,548.09	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	112,865,446.29	127,182,568.69
210201	Тэтгэврийн даатгал	89,233,258.00	102,540,486.80
210202	Тэтгэмжийн даатгал	6,008,984.84	6,653,150.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,807,189.47	5,047,840.78
210204	Ажилгүйдлийн даатгал	1,165,092.45	1,176,462.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,650,921.53	11,764,627.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	128,857,267.00	158,160,873.00
210301	Гэрэл, цахилгаан	29,971,635.00	23,475,036.00
210302	Түлш, халаалт	94,218,622.00	123,193,104.00
210303	Цэвэр, бохир ус	4,667,010.00	11,492,733.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	87,022,794.20	52,176,146.80
210401	Бичиг хэрэг	57,571,727.00	10,091,204.00
210402	Тээвэр, шатахуун	2,097,000.00	2,410,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,927,795.00	10,139,773.00
210404	Ном, хэвлэл	4,862,806.00	4,659,170.00



210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,526,400.00	7,578,193.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	280,600.00	00.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,524,100.20	17,297,806.80
210408	Бараа материал акталсны зардал	2,232,366.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>507,200.00</b>	<b>00.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	507,200.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>60,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	00.00	55,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,806,700.00</b>	<b>39,328,982.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.00	36,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,600.00	138,882.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,493,000.00	2,052,000.00
210807	Газрын төлбөр	00.00	795,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>219,650,210.87</b>	<b>218,244,842.97</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	219,650,210.87	218,244,842.97
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>143,446,815.26</b>	<b>53,277,907.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>143,093,193.00</b>	<b>53,106,450.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	136,320,210.00	47,106,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,772,983.00	6,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>353,622.26</b>	<b>171,457.42</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	353,622.26	171,457.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>79,440,293.64</b>	<b>21,518,046.14</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,833,532.91</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,833,532.91	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-5,833,532.91</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>73,606,760.73</b>	<b>21,518,046.14</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,648,022,589.17	6,839,256,402.20	-408,013,523.77	8,079,265,467.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,648,022,589.17	6,839,256,402.20	-408,013,523.77	8,079,265,467.60
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	73,606,760.73	73,606,760.73
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,648,022,589.17	6,839,256,402.20	-329,039,463.04	8,158,239,528.33



D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,648,022,589.17	6,839,256,402.20	-329,039,463.04	8,158,239,528.33
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,648,022,589.17	6,839,256,402.20	-329,039,463.04	8,158,239,528.33
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,518,046.14	21,518,046.14
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,648,022,589.17	6,839,256,402.20	-307,521,416.90	8,179,757,574.47

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,701,594,001.00</b>	<b>1,541,449,790.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>25,575,819.00</b>	<b>34,707,290.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	25,575,819.00	34,707,290.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	25,575,819.00	34,707,290.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,575,819.00	34,706,990.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,676,018,182.00</b>	<b>1,506,742,500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	93,250,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	50,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	43,250,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,379,694,900.00	1,413,492,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,379,694,900.00	1,413,492,500.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	296,323,282.00	00.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	296,323,282.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,390,701,142.00</b>	<b>1,523,476,394.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,390,701,142.00</b>	<b>1,523,476,394.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,247,328,567.74</b>	<b>1,470,198,486.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	931,830,495.74	1,002,101,768.58
210101	Үндсэн цалин	639,526,029.49	683,348,051.94
210102	Нэмэгдэл	160,267,080.11	205,628,250.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	55,297,838.05	48,195,226.94
210104	Урамшуулал	76,739,548.09	64,930,239.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	127,242,500.00	135,283,700.00
210201	Тэтгэврийн даатгал	83,340,900.00	95,199,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,095,300.00	10,021,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,241,300.00	8,016,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	471,200.00	2,004,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,093,800.00	20,042,000.00



<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>136,329,477.00</b>	<b>158,160,873.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	29,971,635.00	23,244,074.00
210302	Түлш, халаалт	101,690,832.00	123,424,066.00
210303	Цэвэр, бохир ус	4,667,010.00	11,492,733.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,002,062.00</b>	<b>42,840,316.00</b>
210401	Бичиг хэрэг	1,857,278.00	2,485,080.00
210402	Тээвэр, шатахуун	2,097,000.00	1,543,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,228,655.00	15,622,573.00
210404	Ном, хэвлэл	5,257,306.00	4,846,170.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,321,890.00	14,743,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,239,933.00	3,599,993.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,889,333.00</b>	<b>7,322,683.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,889,333.00	7,322,683.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>78,639,164.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	23,639,164.00
210604	Урсгал засвар	00.00	55,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,034,700.00</b>	<b>42,147,982.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.00	37,250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,600.00	138,882.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,721,000.00	3,821,000.00
210807	Газрын төлбөр	00.00	795,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>3,702,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,702,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>143,372,574.26</b>	<b>53,277,907.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>143,018,952.00</b>	<b>53,106,450.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	136,320,210.00	47,106,450.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,698,742.00	6,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>353,622.26</b>	<b>171,457.42</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	353,622.26	171,457.42
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>310,892,859.00</b>	<b>17,973,396.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>287,576,695.00</b>	<b>36,612,560.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>287,576,695.00</b>	<b>36,612,560.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>287,576,695.00</b>	<b>36,612,560.00</b>
220001	Барилга байгууламж	176,486,138.00	00.00
223001	Бусад хөрөнгө	96,520,980.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,569,577.00	36,612,560.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-287,576,695.00</b>	<b>-36,612,560.00</b>



8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	23,316,164.00	-18,639,164.00
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	2,707,174.00	26,023,338.00
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	26,023,338.00	7,384,174.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,444,492,500.00	1,444,326,332.58	166,167.42	99.99
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,444,492,500.00	1,444,326,332.58	166,167.42	99.99
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,391,338,800.00	1,391,219,882.58	118,917.42	99.99
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,002,102,100.00	1,002,101,768.58	331.42	100.00
210101	Үндсэн цалин	639,609,600.00	683,348,051.94	(43,738,451.94)	106.84
210102	Нэмэгдэл	186,728,300.00	205,628,250.39	(18,899,950.39)	110.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	96,800,000.00	48,195,226.94	48,604,773.06	49.79
210104	Урамшуулал	78,964,200.00	64,930,239.31	14,033,960.69	82.23
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	135,283,700.00	135,283,700.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	95,199,700.00	95,199,700.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,021,000.00	10,021,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,016,800.00	8,016,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,004,200.00	2,004,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,042,000.00	20,042,000.00	-	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	158,163,600.00	158,160,873.00	2,727.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	53,372,500.00	23,244,074.00	30,128,426.00	43.55
210302	Түлш, халаалт	88,876,600.00	123,424,066.00	(34,547,466.00)	138.87
210303	Цэвэр, бохир ус	15,914,500.00	11,492,733.00	4,421,767.00	72.22
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	61,005,700.00	60,953,876.00	51,824.00	99.92
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,485,080.00	14,920.00	99.40
210402	Тээвэр, шатахуун	1,600,000.00	1,543,000.00	57,000.00	96.44
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,812,200.00	16,876,673.00	(64,473.00)	100.38



210404	Ном, хэвлэл	21,750,000.00	21,705,630.00	44,370.00	99.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,743,500.00	14,743,500.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,600,000.00	3,599,993.00	7.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,324,600.00</b>	<b>7,322,683.00</b>	<b>1,917.00</b>	<b>99.97</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,324,600.00	7,322,683.00	1,917.00	99.97
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,459,100.00</b>	<b>22,396,982.00</b>	<b>62,118.00</b>	<b>99.72</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,250,000.00	17,250,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	143,100.00	143,100.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,600.00	138,882.00	11,718.00	92.22
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	00.00	50,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,070,400.00	4,070,000.00	400.00	99.99
210807	Газрын төлбөр	795,000.00	795,000.00	-	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53153700.00</b>	<b>53106450.00</b>	<b>47,250.00</b>	<b>99.91</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>53,153,700.00</b>	<b>53,106,450.00</b>	<b>47,250.00</b>	<b>99.91</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,153,700.00	47,106,450.00	47,250.00	99.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,444,492,500.00</b>	<b>1,444,326,332.58</b>	<b>166,167.42</b>	<b>99.99</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,413,492,500.00</b>	<b>1,413,321,042.58</b>	<b>171,457.42</b>	<b>99.99</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,413,492,500.00	1,413,321,042.58	171,457.42	99.99
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>31,000,000.00</b>	<b>31,005,290.00</b>	<b>(5,290.00)</b>	<b>100.02</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,000,000.00	31,004,990.00	(4,990.00)	100.02
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>80.00</b>	<b>80.00</b>	<b>-</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00



620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	53.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	26.00	26.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>93,250,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>93,250,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	93,250,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	55,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00
210604	Урсгал засвар	50,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>38,250,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,250,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>93250000.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>93,250,000.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	50,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,250,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдэлт, үндсэн хөрөнгийн элэгдэл, бүртгэл, засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт, худалдан авалтын и-баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын ахлах аудитор Ш.Наран аудитор Ш.Одням нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер

Аудитын код НТАГ-2022/788/НА-СА-ТШЗ



3. Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 50 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго: *“Нийслэлийн хүн амын боловсрол, соёл, мэдээлэл чөлөөт цагийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн номын сан - ном зүйн үйлчилгээг үзүүлж, бие хүнийг бүтээлчээр хөгжүүлэхэд оршино”* гэж тодорхойлсон байна.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Номын сангийн уншлага, үйлчилгээ
- Интернэт, мэдээллийн үйлчилгээ
- Мэдээллийн нөөц бүрдүүлэх – лавлагаа – ном зүйн үйлчилгээ
- Ном сэлбэн засах үйлчилгээ
- Гэрээр ном олгох үйлчилгээ
- ЕБС-ийн номын санчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар Тус байгууллагын үйл ажиллагаанд Нийслэлийн дотоод аудитын газраас аудитыг хэрэгжүүлдэг бөгөөд тайлант хугацаанд тус хэлтсийн үйл ажиллагаанд аудит хийсэн ч зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.



Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,639.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 24,597.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17,218.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн байдлын тайлангаар өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3=2-1</b>
Мөнгөн хөрөнгө	26,023.3	7,384.1	(18,639.1)
Авлага	5,729.8	19,593.0	13,863.2
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	102,870.6	103,676.5	805.8
Үндсэн хөрөнгө	8,075,454.8	8,056,488.0	(18,966.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,210,078.6</b>	<b>8,187,141.7</b>	<b>(22,936.8)</b>
Өр төлбөр	51,839.1	7,384.1	(44,454.9)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	8,158,239.5	8,179,757.5	21,518.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,210,078.6</b>	<b>8,187,141.7</b>	<b>(22,936.8)</b>

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 26,023.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7,384.1 мянган төгрөг болж 18,639.1 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд дахь үлдэгдэл хасагдсанаас шалтгаалжээ.

Авлага дансны эхний үлдэгдэл 5,729.8 мянган төгрөг байсан нь жилийн эцсийн үлдэгдлээр 19,593.0 мянган төгрөг болж тайлангийн хугацаанд 13,863.2 мянган төгрөгөөр өссөн байна. авлага дансны үлдэгдэл нэмэгдсэн шалтгаан нь НДШ-ийн илүү төлөлттэй гарсан, мөн номын өр төлбөрийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны оны эхний үлдэгдэл 102,870.6 мянган төгрөг, оны эцсийн үлдэгдэл 103,676.5 мянган төгрөг болж 805.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Энэ нь худалдаж авсан бараа материалын дүнгээр өссөн байна.



Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 8,767,397.0 мянган төгрөг, оны эцсийн үлдэгдэл 8,966,675.1 мянган төгрөг болж 199,278.0 мянган төгрөгөөр өссөн. нь барилга байгууламж капиталжуулалт 162,665.5 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авсан 19,753.1 мянган төгрөг, ном хэвлэл худалдан авсан 16,859.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 51,839.1 мянган төгрөг, оны эцсийн үлдэгдэл 7,384.1 мянган төгрөг болж 44,454.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ХХОАТ, НДШ-ийн өр төлбөрийг бүрэн барагдуулснаас мөн жилийн эцсийн үлдэгдэл болох 7,384.1 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл байна.

Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 11,267.4 мянган төгрөгөөр буюу 0.66 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 46,654.8 мянган төгрөгөөр буюу 2,8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс нэмэгдсэн шалтгаан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зэрэг зардлуудын төсөв өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус номын сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,797,073.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,797,073.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 352,581.2 мянган төгрөгөөр бууруулж 1,444,492.5 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг зардлыг 82,118.2 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11,086.0 мянган төгрөгөөр хасагдуулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,000.0 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 126,570.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 17,395.2 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 21,813.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал зардал болон бусад зардлууд 91,598.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг 1,444,492.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөвлөжээ. Гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэр нь 1,413,321.0 мянган төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 31,004.9 мянган төгрөгийг өөрийн орлогоор санхүүжүүлсэн байна. Гүйцэтгэлээр орон нутгийн санхүүжилтээр 1,413,492.5 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд 1,444,326.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 171.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.



Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,444,326.3 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 1,137,385.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 158,160.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 60,953.9 мянган төгрөг, Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 7,322.7 мянган төгрөг, урсгал засварын зардалд 5,000.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд 47,106.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 6,000.0 мянган төгрөг, бусад бараа ажил үйлчилгээний зардалд 22,396.9 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Соёлын сайдаас 43,250.0 мянган төгрөгийг санхүүжилтийг олгожээ. Дээрх санхүүжилтийг соёлын сайдын тушаалын дагуух зориулалтаар нь зарцуулсан байна. Үүнээс багаж техник хэрэгслийн зардалд 5,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 38,250.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн нэмэгдэл санхүүжилтийн дансаар Росмат ХХК-аас компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Хан-уул дүүрэг дэх салбар номын сангийн дээврийн болон барилгын дотор засварын ажлын зардалд зориулж 50,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Нэмэлт санхүүжилтийн дансаар орж ирсэн мөнгийг зориулалтын дагуу 100 хувь зарцуулж дансанд үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Бусад асуудлын хэсэг:**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төсвийн орлого бүрдүүлэх 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.



### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 70 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээллийг тулган шалгахад Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь 2021 онд 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулахаас 148 мэдээллийг бүрэн мэдээлсэн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болох 32,578.3 мянган төгрөгийн 1 гүйлгээг шилэн дансандаа байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг үзэхэд холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

ЗГ-ын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад хангамж бараа материал, норматив зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр зэргээс 10 хувь буюу 9,078.9 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 20 хувь буюу 15,816.3 мянга, нийт 21,916.9 мянган төгрөгөөр хэмнээгүй, 2,507.8 мянган төгрөгийн нормын хувцас, уншигчдын хувцас хийх даавуун уут худалдан авсан зэрэг нь дээрх тогтоолын 1.1. "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;", 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; 1.8. "байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах;" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий дээд байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллаж байх албан шаардлага өгөв.

### 3.10. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 3.10.1. Завсрын аудитын үр дүн:

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудал гараагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 12,486.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Бараа материалын тайланд түлш, шатахуун худалдан авсныг тусгаагүй шууд зардлаар тайлагнасан	1	450,0	1	450,0	-	-	-
Тайлант хугацаанд цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн	1	12,036.5	1	12,036.5			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>12,486.5</b>	<b>2</b>	<b>12,486.5</b>	-	-	-

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,360.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14,360.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой залруулсан алдаа гараагүй.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:



#### **4.2.1 Зардлын данстай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Дансны хуулга, И баримтыг тулган шалгахад тайлант хугацаанд хийгдсэн худалдан авалтын төлбөрийн 14,360.4 мянган төгрөгийг И баримтгүй (бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг цахим системд дутуу бүртгүүлсэн) шилжүүлсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг тус тус зөрчсөн.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 , Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6," Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөн заавар"-ын 6.5 заалтыг хэрэгжүүлж, төлбөрийн и-баримтыг тухай бүр нь бүрдүүлж ажиллах;

#### **Балансын данстай холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 302,483.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох;" заалтыг зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Хөрөнгийг дахин үнэлж бүртгэх талаар ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.